



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

**Аудитын сэдэв:** Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө

**Аудитын гол дүгнэлт:** Үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтоолцоо нь тухайн байгууллага, төсөв санхүүгийн үйл ажиллагааг зөв зохистой удирдан зохион байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжийг цаг алдалгүй авч тусламж, үйлчилгээ үзүүлэх сайн тал бол гэрээнд заагдаагүй гэх шалтгаанаар иргэдэд үзүүлсэн тусламж үйлчилгээний санхүүжилтийг бүрэн авч чадахгүй байх сул талтай байна.

**Тайланг хүргүүлсэн этгээд:**

Аудитын тайланг Үндэсний аудитын газрын гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс

**Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:**

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор Г.Даваа  
Утас: 70518396 Цахим хаяг: [davaag@audit.gov.mn](mailto:davaag@audit.gov.mn)

Аудитын менежер М.Нарантуяа  
Утас: 70512123 Цахим хаяг: [narantuyam@audit.gov.mn](mailto:narantuyam@audit.gov.mn)

Ахлах аудитор А.Ариунбаяр  
Утас: 99076224 Цахим хаяг: [Ariunbayars@audit.gov.mn](mailto:Ariunbayars@audit.gov.mn)

Аудитор Б.Ариунзул  
Утас: 89133344 Цахим хаяг: [Ariunzulb@audit.gov.mn](mailto:Ariunzulb@audit.gov.mn)

Аудитор А.Мөнхцэцэг  
Утас: 99784578 Цахим хаяг: [Munkhtsetsega@audit.gov.mn](mailto:Munkhtsetsega@audit.gov.mn)

Баруун-Урт 2023 он

|                                       |                                                                                                                                                                                                                                                              |
|---------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b> | Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоолын дагуу хийв. |
| <b>Аудитын зорилт</b>                 | Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.                   |
| <b>Аудитын хамарсан хүрээ</b>         | Аудитад Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, сум, өрхийн төвийн 2021-2022 оны үйл ажиллагааг хамруулав.    |

**БҮЛЭГ А. Хөгжлийн бодлогын дунд болон богино хугацааны баримт бичигт заасан эрүүл мэндийн даатгалын чанар хүртээмжийн талаар тусгасан бодлогын зорилтын тайлагнах хугацаа болоогүй ч засаг даргын хөтөлбөрт тусгасан арга хэмжээний гүйцэтгэл 88.4 хувийн хэрэгжилттэй байна.**

**А.1. Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 88.4 хувийн биелэлттэй байна.**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэх 39 зорилт арга хэмжээг тусгасан байна. Бодлогын баримт бичигт эрүүл мэндийн даатгалын сан, үйл ажиллагаатай холбоотой дараах арга хэмжээ тусгагдсан байна. Үүнд:

- Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын сангаас олгох зардлын ялгааг үе шаттайгаар арилгах;
- Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг бүрэн нэвтрүүлнэ;
- Иргэд орчин үеийн эмчилгээ, оношилгооны өндөр өртөгтэй, нарийн төвөгтэй, оношилгоо, эмчилгээ хийлгэх тохиолдолд зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас олгох үйл ажиллагааг өргөжүүлнэ;
- Иргэн, даатгуулагч эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээ болох сэргээн засах, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ авах зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлнэ;

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар бодлогын баримт бичгийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг баталсан ч хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүйгээс төлөвлөсөн үр дүнг тооцох боломжгүй байгаа бол аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан эрүүл мэндийн чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хяналт-шинжилгээ үнэлгээгээр 88.4 хувьтай үнэлсэн байна.

### **А.1.2 Эрүүл мэндийн нийт зардалд иргэний төлөх төлбөр 36.4 хувийг эзэлж байгаа нь бусад орноос өндөр үзүүлэлттэй байна.**

Дэлхийн улс орнуудын эрүүл мэндийн даатгалын тогтолцоог дараах хэлбэрээр хэрэгжүүлж байна. Үүнд:

- Засгийн газраас санхүүждэг буюу нэг төлбөрт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Бүх нийтийн даатгалын тогтолцоо;
- Бүх нийтийн төр, хувийн хэвшлийн даатгалын тогтолцоо;
- Бүх нийтийн хувийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоо;
- Бүх нийтийн бус даатгалын тогтолцоо;

Бүх нийтийн даатгалын тогтолцоогоор иргэдээ эрүүл мэндийн даатгалд хамруулж буй улс орнуудын ДНБ-д эзлэх эрүүл мэндийн зардлын эзлэх хувийг тооцон гаргасан судалгаанаас харахад Монгол улсын хувьд ДНБ-д эзлэх улсын зардал 3.5 хувь, ЗГ-ын зардалд эзлэх зардал 10.3 хувь байгаа нь бусад улс орноос бага байгаа бол, эрүүл мэндийн нийт зардалд иргэний төлөх төлбөр 36.4 хувийг эзэлж байгаа нь өндөр үзүүлэлттэй байна.

**БҮЛЭГ Б. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг хэт өндөр төлөвлөснөөс орлого тасарсан, тусгай шаардлагад тэнцээгүй лавлагаа шатлалын эмнэлгийг сонгон шалгаруулсан, төлбөрийн нэхэмжлэлийн хасагдлын шалтгаанд хариу тайлбар хүргүүлээгүй, ЭМБ-д хийх хяналт шалгалт хангалтгүй, программ хангамжийн сургалт үр дүнгүй байна.**

### **Б.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 58.9 хувьтай хэрэгжжээ.**

Эрүүл Мэндийн Даатгалын Үндэсний Зөвлөлөөс аймгийн даатгалын сангийн орлогыг 2021 онд 4,112.4 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэл 4,265.8 сая төгрөг төвлөрч 103.7 хувьтай байгаа бол 2022 онд сангийн орлогын төлөвлөгөөг 7,599.7 сая төгрөгөөр баталж гүйцэтгэл 4,477.2 сая төгрөг төвлөрч 58.9 хувьтай байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2021 онд нийт дүнгээр 103.7 хувиар хэрэгжсэн боловч даатгуулагч өөрөө төлөх орлогын төлөвлөгөө 67.5 сая төгрөг буюу 14.5 хувиар тасарсан байна.

ЭМДҮЗ-өөс орлогын төлөвлөгөөг баталж байгаа бөгөөд 2022 оны орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээс 3,333.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталснаас даатгалын сангийн орлого тасарсан байна. Сангийн орлого тасарсан шалтгааныг тодруулж үзэхэд ЭМДҮЗ-өөс орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлэн батлах болсон шалтгаан, тайлбарыг аймгийн НДХ-т ирүүлээгүй байна.

ЭМДЕГ-аас даатгалын сангийн орлого бүрдүүлэхтэй холбоотойгоор 5.4 сая төгрөгийг олгосон бол 2022 онд үйл ажиллагаанд зарцуулах зардал хуваарилаагүй байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7<sup>1</sup>-т заасныг зөрчсөн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, ЭМДҮЗ-ийн 2022 оны 16<sup>2</sup> тогтоолд Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 1,100.0 сая төгрөг олгохоор баталсан байна. Иймд НДЕГ нь даатгалын сангийн орлого бүрдүүлэхтэй холбоотой гарсан зардлыг санхүүжүүлэх хөрөнгийг орон нутгийн НДХ-т хуваарилаагүй байх эрсдэлтэй байна.

<sup>1</sup> нийгмийн даатгалын байгууллагын энэ хуулийн 19.3-т заасан үйл ажиллагааны зардал;

<sup>2</sup> Төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай

## **Б.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хасагдсан төлбөрийн нэхэмжлэлийн талаарх шалтгаан тайлбарыг хүргүүлээгүй байна.**

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлд ЭМДҮЗ-өөс баталсан журмын дагуу хяналт хийж 2021 онд шалгуур үзүүлэлт хангаагүй 3,956 иргэнд үзүүлсэн тусламж үйлчилгээний 1,777.7 сая, 2022 онд 13,916 иргэн үзүүлсэн тусламж үйлчилгээний 1,748.8 сая төгрөгийг тус тус хасаж тооцсон байна

Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэл дараах нийтлэг алдаанаас болж хасагдсан байна. Үүнд:

- *Анхан шатны баримт хангалтгүй, баримт ирүүлээгүй;*
- *Эмчилгээг давхардуулан нэхэмжилсэн, тусламж үйлчилгээний төрлийг сольж мэдээлсэн;*
- *Өвчтөний түүхэд оношилгоо, шинжилгээний хуудас хавсаргаагүй;*
- *Хэвтэн эмчлүүлэгчийн өвчний оношны хамаарлын кодын буруу нэхэмжилсэн;*
- *Бодит цагийн горим баримтлаагүй;*

Цахим систем дараах нийтлэг алдаанаас шалтгаалан төлбөрийн нэхэмжлэлийг хасаж тооцсон байна. Үүнд:

- *Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэнд үзүүлсэн тусламж үйлчилгээг нэхэмжлэх;*
- *Оношны хамаарлын бүлгийн нэр, кодыг зөрүүтэй нэхэмжлэх;*
- *Амбулатори, яаралтай тусламж, хэвтэн эмчлүүлсэн иргэний эрүүл мэндийн тусламж үйлчилгээг давхардуулах зэрэг алдаанаас шалтгаалан төлбөрийн нэхэмжлэл хасагдаж байна.*

Нийт хасагдлын мэдээллээр 2021 онд 65.6 хувь, 2022 онд 29.2 хувийг Ковид цар тахлаар өвчилсөн иргэдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийн хасагдал эзэлжээ.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний нэхэмжлэлд хяналт хийж хасагдлын шалтгааныг хавсралтаар хүргүүлж байгаа бол өрх, сумын ЭМТ-д шалтгаан тайлбарыг хүргүүлээгүй байна. Энэ нь ЭМДҮЗ-ийн 2022 оны 12<sup>3</sup> дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 4 дүгээр зүйлийн 4.1.2.3-т заасныг зөрчсөн байна.

Нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээг бүртгэх дотоод сүлжээнд суурилсан “e-health” цахим системээс авсан мэдээллээр 2021 онд нийт хасагдсан дүнгийн 91.9 хувийг цахим, 8.1 хувийг байцаагчийн хяналт, 2022 онд 58.5 хувийг цахим, 41.5 хувийн байцаагчийн хяналтаар хассан байна.

## **Б.3. Аймгийн хэмжээнд 10,000 хүн амд ногдох их эмчийн тоо улсын дунджаас доогуур байна.**

Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн бүтцийг ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/10 дугаар тушаалаар хэлтсийн дарга 1, чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн 3 орон тоотой байхаар баталснаас 1 орон тоо дутуу ажиллаж байна.

Чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтын тусгай шалгуурт эрүүл мэнд, бизнес удирахуйн чиглэлээр их дээд сургууль төгссөн байхаар тусгасан нь сул орон тоог нөхөхөд хүндрэл үүсгэж байна. Мөн дараах нөхцөл байдлын улмаас сул орон тоог нөхөх боломжгүй байна.

<sup>3</sup> Чанар, төлбөрийн хяналтын журам

- Төрийн албаны тухай хуульд заасны дагуу эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь төрийн албаны ерөнхий шалгалтад хамрагддаггүй;
- Дээрх мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод албан тушаалын ангилал, зэрэглэлийг ТЗ-6 цалинжихаар тусгасан нь эмч, эмнэлгийн мэргэжилтний цалингаас бага;
- Орон тоо дутагдалтайгаас зарим төрлийн ажил үүргийг хавсран гүйцэтгэж, ажлын ачаалал их байгаа зэрэг нь нөлөөлжээ;

Аймгийн хэмжээнд 2021 оны байдлаар 10,000 хүнд ногдох их эмч 24.5, сувилагч 37.4 ногдож байгаа өмнөх оны үзүүлэлтээс их эмч 1.3 промилиар буурсан бол сувилагч буюу эмнэлгийн тусгай мэргэжилтэн 1.4-өөр нэмэгджээ. Харин уг үзүүлэлтийг улсын дундаж үзүүлэлттэй харьцуулж үзэхэд их эмч 15, сувилагч, эрүүл мэндийн тусгай мэргэжилтэн 3.6 промилиар доогуур үзүүлэлттэй байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийг төлөөлөн удирдах зөвлөл, түүний томилсон дарга удирдлагыг хэрэгжүүлэхээр Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4<sup>4</sup>-т заасан байна.

Нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулаагүй, эмнэлгийн удирдлагыг аймгийн ЭМГ-ийн дарга, Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр томилж байгаа нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2<sup>5</sup>, 17 дугаар зүйлийн 17.10.5<sup>6</sup>-т заасантай нийцэхгүй байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан шалгуурыг хангасан гишүүдээр эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулж, эмнэлгийн тусламж үйлчилгээ болон төсөв санхүүгийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдах, зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллах нь зүйтэй байна.

#### **Б.4. Сонгон шалгаруулалт хийхэд зайлшгүй тавигдах шаардлагыг бүрэн хангаагүй эмнэлгийг шалгаруулж, гэрээ байгуулжээ.**

Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг 2021 онд сонгон шалгаруулахгүйгээр шууд гэрээ байгуулсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1<sup>7</sup> -т заасныг зөрчсөн байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам"-ын 1.4 -т зааснаар (Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 17.1 ) сумын ЭМТ-тэй сонгон шалгаруулалтгүйгээр шууд гэрээ байгуулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам"-ын 1.4<sup>8</sup>-т зааснаар (Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 17.1<sup>9</sup>) сумын ЭМТ-тэй сонгон шалгаруулалтгүйгээр шууд гэрээ байгуулсан байна.

<sup>4</sup> Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.

<sup>5</sup> Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нь тухайн шатны Засаг даргатай зөвшилцөж, харьяа нэгдсэн эмнэлгээс бусад эрүүл мэндийн байгууллагын даргыг хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлнө.

<sup>6</sup> эмнэлгийн захирлыг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх;

<sup>7</sup> Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь энэ хуулийн 16.1.4-т заасны дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон эмийн сантай даатгалын гэрээ /цаашид "гэрээ" гэх/-г байгуулах бөгөөд гэрээний хэрэгжилтийг хянаж, дүгнэнэ.

<sup>8</sup> Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т заасан улсын төсвөөр санхүүжүүлэх тусламж, үйлчилгээг сонгон шалгаруулалтад хамруулахгүйгээр тэдгээр байгууллагатай шууд гэрээ байгуулж болно.

<sup>9</sup> Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үзүүлэх Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6-д заасан тусламж, үйлчилгээний зардлыг улсын төсвөөс дараахь аргаар санхүүжүүлнэ:

Лавлагаа шатлалын эмнэлгүүд “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2-т заасан ерөнхий шалгуурыг хангажээ. Харин хувийн хэвшлийн эмнэлгүүд ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/48<sup>10</sup> дугаар тушаалаар баталсан тусгай шаардлагад заавал байх техник, тоног төхөөрөмжийг тулган үзэхэд дараах зөрчил илэрсэн. Тухайлбал: Тусгай шаардлагад заасан оношны хамааралтай бүлгээр заавал байх оношилгооны болон шинжилгээний тоног төхөөрөмжгүй, тухайн оношилгоо шинжилгээг аймгийн нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлэхээр тусгасан байхад сонгон шалгаруулжээ.

Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг эрхэлж байгаа эмийн сангуудыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4<sup>11</sup>-т заасны дагуу сонгон шалгаруулахгүйгээр шууд гэрээ байгуулсан байна.

Аймгийн хэмжээнд ЭМДБ-тай гэрээ байгуулж, эмийн үнийн хөнгөлөлт үзүүлдэггүй 7 эмийн сан байна. Үүнээс 3 эмийн сан 2022 онд шинээр байгуулагдсан бөгөөд хөнгөлөлттэй эмийн үйлчилгээг үзүүлэх хүсэлт гаргасан боловч зарим тусгай шаардлагыг хангаагүй учир гэрээ байгуулаагүй байна. Иймд дээрх эмийн сангууд даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээнд хамруулж иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй хүргэхэд анхаарч ажиллах нь зүйтэй байна.

#### **Б.5. Гэрээний хэрэгжилт дүгнэх аргачлалын зарим заалт бодит байдалтай нийцээгүй байна.**

Аймгийн хэмжээнд 2021 онд нэгдсэн эмнэлэг, уламжлалтын эмнэлэг, өрх, сумын ЭМТ, хувийн хэвшлийн эмнэлэг болон 21 эмийн сан нийт 41 байгууллагатай эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээг байгуулсан байна.

Лавлагаа шатлалын эмнэлгийн 2021 оны гэрээний хэрэгжилтийг ЭМДЕГ-ын даргын 2018 оны А/142 дугаар тушаалаар баталсан журмын хоёрдугаар хавсралтаар төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, сувиллыг дүгнэх үнэлгээний хуудсаар зайнаас (ЭМДЕГ-т) дүгнэж 92-95 оноогоор үнэлжээ.

Лавлагаа шатлалын эмнэлгийн даатгалын гэрээг үнэлэх аргачлалын зарим заалт үйл ажиллагааны стандарт, үйлчилгээний чанарыг бодитоор үнэлэхэд хангалтгүй байна. Тухайлбал:

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын жилийн санхүүжилтийн 70-90 хувийг ЭМДС-ийн орлого бүрдүүлж байхад үнэлэх аргачлалд үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ЭМДС-аас авах орлогын 20 хувиас бага бол 5 оноо, 20-30 хувь бол 3 оноо, 30 хувиас дээш бол 0 оноогоор дүгнэхээр тусгасан;
- Тусламж үйлчилгээний талаар даатгуулагчаас гомдол ирсэн бол 3 оноо, үгүй бол 0 оноогоор дүгнэхээр тусгасан нь тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанаргүй хэрэгжүүлэхэд өндөр оноо өгөх;
- ЭМДЕГ-аас цахим хэлбэрээр гэрээг дүгнэх нь эмчилгээ, оношилгооны стандарт, эмнэл зүйн удирдамжийн мөрдөлт, үйлчилгээний чанарыг үнэлэхэд бодит үнэлгээ болж чадахгүй байх эрсдэлтэй байна;

<sup>10</sup> “Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулахад тавигдах тусгай шаардлага” батлах тухай

<sup>11</sup> Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн өмчийн бүх хэлбэрийн эмийн сангаас бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нь харгалзан сонгон шалгаруулах үйл ажиллагааг энэ хуулийн 14.9.11-д заасан журмын дагуу зохион байгуулах;

Сумын ЭМТ-үүд 2022 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг 9 төрлөөр үзүүлэхээр гэрээ байгуулжээ. Энэ нь сумын иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Өрхийн болон сумын ЭМТ-ийн 2021 оны даатгалын гэрээний хэрэгжилтийг баталсан маягт, шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалын дагуу үнэлж дунджаар 84.3 оноотой дүгнэжээ.

#### **Б.6. Лавлагаа шатлалын эмнэлгүүд хэвтэн эмчлүүлсэн оношны хамаарлын бүлгийн төлбөрөөс илүү төлбөр нэхэмжилжээ.**

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад 2021 онд 266,041 иргэний тусламж үйлчилгээнд 15,433.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 12,110.2 сая төгрөг олгож 3,323.1 сая төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021 онд олгосон нийт санхүүжилтийн 8,883.6 сая төгрөг буюу 57.5 хувь, 2022 онд 1,858.3 сая төгрөг буюу 8.7 хувийг ковид цар тахлаар өвчилсөн иргэдэд үзүүлсэн тусламж үйлчилгээ, дархлаажуулалттай холбоотой санхүүжилт эзэлж байна.

Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагад олгосон санхүүжилт үр нөлөөтэй эсэхийг анхан шатны баримтаар түүвэрлэн баталгаажуулахад оношны хамаарлын бүлэг буруу нэхэмжилсэн, анхан шатны баримтгүй 26.8 сая төгрөгийн санхүүжилт илүү нэхэмжилж Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6<sup>12</sup>, 16 дугаар зүйлийн 16.1.5<sup>13</sup>-т заасныг зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо.

Сумын ЭМТ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3<sup>14</sup> дахь заалттай холбоотойгоор хэвтэн эмчлүүлэгч ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолын нэгдүгээр<sup>15</sup> хавсралт, гуравдугаар хавсралтаар баталсан журмын 4 дүгээр зүйлийн 4.1<sup>16</sup>-т заасны дагуу иргэний хариуцах төлбөрийг тооцож төлүүлэхгүй байна.

2.6.15 Иймд дээрх хуулийн заалтад нэмэлт өөрчлөлт оруулж сумын ЭМТ-д хэвтэн эмчлүүлсэн даатгуулагч иргэн “ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношны хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ”-д заасан төлбөрийг төлдөг болсноор ЭМДС-ийн санхүүжилтийг жилд дунджаар 1,366.2 сая төгрөгөөр (ангалагдаагүй бусад ОХБ даатгуулагч 34,500 төгрөг төлнө. Нэг эрүүл мэндийн төв дунджаар 10 хүн хэвтэн эмчлүүлэхэд жилд 4.1 сая төгрөгийн орлого төвлөрөх боломжтой гэж үзсэн. Үүнийг 330 сумаар тооцож үзэхэд дээрх хөрөнгийг даатгалын сангаас хэмнэх боломжтой.) хэмнэх боломж байна.

#### **Б.7. Эрүүл мэндийн даатгалд хамралтын төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна.**

Сүхбаатар аймгийн хэмжээнд ЭМД-д 2021 онд 90%, 2022 онд 90.1 хувьтай хамрагдсан байна. Иргэдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг улсын дундаж үзүүлэлттэй

<sup>12</sup> эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;

<sup>13</sup> даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, энэ хуулийн 14.8.7-д заасан журамд тусгагдсан шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлбөр олгох;

<sup>14</sup> Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв энэ хууль болон Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаас бусад тохиолдолд иргэнээс төлбөр авч тусламж, үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

<sup>15</sup> Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношны хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ

<sup>16</sup>

харьцуулж үзэхэд 2021 онд дундаж түвшинд байгаа бол 2022 онд дунжаас 2.5 хувиар доогуур байна.

Эрүүл мэндийн даатгалд 2020-2022 онд хамрагдсан нийт иргэдийн 74.5-82.5 хувь буюу 44,307-48,020 иргэний даатгалыг төр хариуцан төлж байна. Уг үзүүлэлтийг улсын дундаж үзүүлэлттэй харьцуулж үзэхэд дунджаас 8.1 хувиар их байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/10, 2022 оны А/13 дугаар тушаалын хавсралтаар хамралтын төлөвлөгөөг баталсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг авч үзвэл дээрх онуудад дунджаар 32.0-46.4 хувийн гүйцэтгэлтэй гарч байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг олгосноор дараах давуу болон сул тал гарч байна. Үүнд:

**Давуу тал:**

- Тайлант жилийн зарцуулагдаагүй үлдэгдлийг дээд шатны төсвийн дансанд төвлөрүүлэхгүйгээр он дамжуулан зарцуулах боломжтой болсон;
- Эмч, эмнэлгийн ажилчдын нийгмийн асуудал, цалин урамшууллыг хууль, эрх зүйн орчинд тусгасны дагуу шийдвэрлэх;
- Шинэ дэвшилтэд технологид суурилсан тоног төхөөрөмжийг худалдан авч, эмчилгээ, оношилгооны төрлийг нэмэгдүүлэх;

**Сул тал:**

- Дараагийн шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамрагдахын тулд 13а маягт шаардах нь иргэдэд чирэгдэл учруулах;
- Өндөр өртөгтэйгөөс бусад оношилгоо шинжилгээний зардал нь багцын зардлаас илүү гарсан тохиолдолд санхүүжилтийг олгохгүй байх;
- Эрүүл мэндийн даатгалын төлөлт дутуу болон даатгалд хамрагдаагүй амь тэнссэн тусламж үйлчилгээний зардлын санхүүжилтийг авч чадахгүй байх сул тал байна.
- Үйлчилгээ авч буй иргэдийн бүртгэл мэдээлэл нь улсын бүртгэлийн системд алдаатай бүртгэгдсэн байдлаас болж үзлэг нэхэмжлэгдэхгүй тохиолдол үүсэж байна.

**Б.8. Сум, өрхийн ЭМТ-д ашиглагдаж байгаа программын сургалт, сурталчилгаа хангалттай хийгээгүйгээс хүндрэл бэрхшээл үүссэн байна.**

Даатгалын байгууллагад ашиглагдаж байгаа health.gov.mn программын мэдээллийн бааз нь нэгдсэн байдлаар татагдахгүй, зөвхөн хэсэгчилсэн хэлбэрээр хөрвөж байгаа нь дүн шинжилгээ, хяналт хэрэгжүүлэхэд ажлын ачаалал нэмэх сул талтай байна.

Сумын ЭМТ-үүд 2022 оны сүүлийн хагас жилээс e-hospital цахим системийг ашиглан эрүүл мэндийн туламж, үйлчилгээний бүртгэл, төлбөрийн нэхэмжлэлийг үүсгэж байна.

Шинэ цахим систем нэвтрүүлж байгаатай холбоотойгоор эмч, эмнэлгийн ажилчдад танхимын сургалт явуулаагүй, сургаж дадлагажуулаагүй зөвхөн цахим хэлбэрээр сургалт хийгдсэн нь e-hospital программыг үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд хүндрэл үүсэж, зарим тусламж, үйлчилгээний төлбөрийг нэхэмжилж чадаагүй байна.

**Б.9 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон эмч, эмнэлгийн ажилтны ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол буурахгүй байна.**

Эрүүл мэндийн даатгалын хэлтэст 2021 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон, цахим бүртгэлтэй холбоотой 6, 2022 онд 2 өргөдөл ирснийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т заасан хугацаанд холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлж, шийдвэрлүүлсэн байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэг хэвтэн эмчлүүлсэн болон яаралтай тусламж үйлчилгээ авсан иргэдээс эм тариа, материалын зардал гаргуулсан, эмч амбулаторийн үзлэгээр хөнгөлөлттэй эмийг жороор бичихгүй өрх, сумын ЭМТ рүү буцааж чирэгдэл учруулж байгаа гомдол ирүүлснийг зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж шийдвэрлүүлсэн байна.

Аймгийн ЭМГ-т иргэдээс 2021-2022 онд бичгээр 4 гомдол ирсний 2 гомдлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 2 гомдлыг аймгийн нэгдсэн эмнэлэг, онцгой комиссын тандалтын багт шилжүүлэн, шийдвэрлүүлсэн байна.

Нэгдсэн эмнэлгийн Чанарын албанд 2021 онд ирсэн өргөдөл гомдлыг ангилан авч үзвэл: эмчилгээний чанартай холбоотой 5, эмч ажилчдын харилцаа хандлагатай холбоотой 2, түргэн тусламжийн дуудлагатай холбоотой 3, хоол үйлдвэрлэл, хүлээгдэл, чирэгдэл зэрэг бусад асуудлаар 21 гомдол ирсэн байна.

2.9.9 Харин 2022 онд эмчилгээний чанартай холбоотой 8, эмч ажилчдын харилцаа хандлагатай холбоотой 5, бусад асуудлаар 8 гомдол ирснийг холбогдох албан тушаалтанд танилцуулж, асуудалд холбогдсон эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй уулзалт хийх, сургалт явуулах зэрэг арга хэмжээг авчээ. Гэсэн хэдий ч эмчилгээний чанар, ёс зүйн харилцаа хандлагатай гомдол өмнөх оноос өссөн, хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнгүй байгааг илтгэж байна.

**Б.10 Төрөөс баримтлах бодлого үндэсний хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.**

Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор Засгийн Газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого 2017-2026 он", 2018 оны 163 дугаар тогтоолын хавсралтаар "Осол гэмтлээс сэргийлэх" үндэсний хөтөлбөрийг 2018-2022 онд хэрэгжүүлэхээр баталж, үндэсний хөтөлбөрийн хүрээнд бүх шатны Засаг даргад хариуцуулсан боловч хяналт, шинжилгээ үнэлгээг хийгээгүй байна.

Эрүүл мэндийн сайд иргэдийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд хүрэх тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт даалгажээ. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Сүхбаатар аймагт төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт талаар мэдээ мэдээлэл өгөөгүй байна.

**Б.11 Тусгай шаардлагад нийцээгүй оношны хамаарлын бүлгийн тусламж, үйлчилгээг цуцалжээ.**

Аймгийн ЭМД-ийн хэлтсээс ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмын 3.1.5, ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/60 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан журмыг үндэслэн лавлагаа шатлалын эмнэлгүүдэд газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлжээ.

Алдаа, зөрчилтэй холбоотойгоор хувийн хэвшлийн эмнэлгийн гэрээгээр гүйцэтгүүлэх оношилгоо шинжилгээний жагсаалтыг гаргуулж алдаа зөрчлийг газар дээр нь арилгуулсан бол ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмын 5 дугаар зүйлийн 5.4.1-т заасан шаардлагыг хангаагүй оношны хамаарлын бүлгээр тусламж, үйлчилгээ үзүүлэхийг цуцалж гэрээний хавсралтаас хассан байна. Тухайлбал:

- *Мижарс эмнэлэг: Оношны хамаарлын бүлгийн зайлшгүй байх шаардлагад тусгасан тоног төхөөрөмжийг харилцагч байгууллагатай гэрээг байгуулж ашиглахаар тусгасан (011011-хөдөлгөөний эмгэгүүд);*

- Эхэн-Ус эмнэлэг: зайлшгүй байх шаардлагатай эмчийн орон тоог гэрээгээр гүйцэтгүүлж байсан (072381-цөсний замын бусад өвчин);
- Оточ болор эмнэлэг: мөн шаардлагад зайлшгүй байхаар тусгасан оношилгоо, тоног төхөөрөмж, эмч зэргийг гэрээгээр гүйцэтгүүлж байсан 7 оношны хамаарлын бүлгийн тусламж үйлчилгээг тус тус хассан байна;

#### **Б.12 Эрх бүхий байгууллагууд хууль тогтоомж, журамд заасан хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.**

ЭМДЕГ-аас шинжээч эмч томилон аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлсэн 321 иргэний өвчтөний түүх, ерөнхий мэргэжлийн яаралтай тусламжийн хуудас 518, гэмтлийн яаралтай тусламжийн хуудас 160 татан авч хяналт шалгалт хэрэгжүүлсэн боловч хяналт, шалгалтаар илэрсэн, алдаа, зөрчлийг танилцуулаагүй байна.

Аймгийн МХГ-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллагын үйл ажиллагааны чанар, эмчилгээний стандартыг мөрдөж буй эсэхэд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Засгийн газраас УИХ-д "Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай" хуулийн төсөл өргөн барьсантай холбоотой байна.

Аймгийн ЭМГ-аас хяналт, шинжилгээ үнэлгээг удирдамжийн дагуу нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн ЭМТ-дэд хийж гүйцэтгэсэн байна. Хяналт шалгалтыг бодлогын баримт бичгийн хэрэгжилт, эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон НЭМ-ийн чиглэлээр хэрэгжүүлж дараах нийтлэг алдаа зөрчил илэрснийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, зөвлөмж өгчээ.

Хяналт, шинжилгээ үнэлгээгээр илэрсэн зөрчилтэй холбогдуулан алдааг арилгах зөвлөмжийг шалгаагдагч байгууллагад хүргүүлж байгаа боловч хэрэгжилтийг хангуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

#### **Дүгнэлт:**

1. Алсын хараа-2050 бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй ч аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр 88.4 хувьтай хэрэгжиж байгаа бол эрүүл мэндийн нийт зардлын 36.4 хувийг иргэн өөрөө хариуцан төлж байна.
2. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын болон даатгалд хамралтын төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна.
3. Тусгай шаардлагад нийцээгүй лавлагаа шатлалын эмнэлгийг сонгон шалгаруулсан, лавлагаа шатлалын эмнэлгийн 2022 оны гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, гэрээний хэрэгжилт дүгнэх шалгуур үзүүлэлтийг алдаатай боловсруулсан байна.
4. Аймгийн нэгдсэн эмнэлгээс бусад байгууллагад төлбөрийн нэхэмжлэлийн шалтгаан, тайлбарыг хүргүүлээгүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан санхүүжилт анхан шатны баримтаар нотлогдохгүй, өвчтөний түүх дэх оношны кодоос өөр дүнгээр буюу илүү дүнгээр нэхэмжлэл үүсгэж санхүүжилт авсан байна.
5. Ковид цар тахлаар өвчилсөн иргэдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд бодит цагийн хяналт хэрэгжүүлээгүй.
6. Сум, өрхийн ЭМТ-д ашиглагдаж байгаа программын сургалтыг үр дүнтэй хийгээгүйгээс 7-8 сард үзүүлсэн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг бүрэн авч чадаагүй байна.

7. Эрх бүхий байгууллагаас бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ хангалтгүйгээс хөтөлбөр, арга хэмжээ хангалтгүй хэрэгжиж байна.
8. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтний тоо 10,000 хүн амд ногдох улсын дунджаас доогуур үзүүлэлттэй, иргэдээс тусламж, үйлчилгээ, эмч ажилчдын ёс зүйтэй холбоотой гомдол буурахгүй байна.
9. Үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтоолцоо нь тухайн байгууллага, төсөв санхүүгийн үйл ажиллагааг зөв зохистой удирдан зохион байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжийг цаг алдалгүй авч тусламж, үйлчилгээ үзүүлэх сайн тал бол гэрээнд заагдаагүй гэх шалтгаанаар иргэд үзүүлсэн тусламж үйлчилгээний санхүүжилтийг бүрэн авч чадахгүй байх сул талтай байна.

## **ЗӨВЛӨМЖ:**

### **Эрүүл мэндийн газарт**

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ болон дотоод хяналтаас гарсан шийдвэрийн биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулж, алдаа, зөрчил давтан гаргасан байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, тэгш байдлыг хангаж ажиллах;
2. Эмч, эмнэлгийн ажилчдын ёс зүй, харилцаа хандлагад чиглэсэн сургалт сурталчилгааг тогтмол явуулж, удаа дараа зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцож хэвших;

### **Эрүүл мэндийн даатгалын хэлтэст:**

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлбөрийн нэхэмжлэлийн хасагдлын шалтгаан, тайлбарыг цаг тухай бүр хүргүүлж, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах;
2. Хөнгөлөлттэй эмийн үйлчилгээ үзүүлэхгүй байгаа эмийн сангуудтай даатгалын гэрээ байгуулах ажлыг шалгуур үзүүлэлтийн дагуу зохион байгуулж, иргэдэд тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэхэд хяналтыг чиглүүлэх;
3. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах ажлыг НДХ-тэй хамтран зохион байгуулж ажиллах;
4. Иргэдэд ЭМДС-ийн талаарх сургалт сурталчилгааны ажлыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж, хамралтын төлөвлөгөөг хангаж ажиллах;
5. Даатгалын гэрээний хэрэгжилтийг, гэрээнд заасан хугацаанд багтаан мөрдөж буй шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэх, хангалттай үнэлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад урамшуулал олгох ажлыг зохион байгуулах;
6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллагад ашиглагдаж байгаа программ хангамжийн хүндрэл бэрхшээл, эрсдэлийг тухай бүр авч дээд шатны байгууллагад уламжилж, программын шинэчлэл, хөгжүүлэлт хийхэд анхаарч ажиллах;

### **Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн төвд**

1. Иргэдэд, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, ЭМДС-ийн талаарх мэдээллийг хуульд заасны дагуу хүргэх ажлыг зохион байгуулж ЭМДХ-тай хамтран ажиллах;
2. Тусламж, үйлчилгээ үзүүлсэн төлбөрийг бодит цагийн горим тулгуурлан, үнэн зөв, нэхэмжилж, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;
3. Тайлант оны статистик мэдээ, судалгаанд дүн шинжилгээ хийж НЭМ-ийн чиглэлээр хэрэгжүүлэх сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг статистик мэдээ тайлантай уялдуулан боловсруулах;
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний анхан шатны баримтыг үнэн зөв, бүрэн хөтөлж, цаг тухай бүр архивын нэгж үүсгэн хариуцсан албан тушаалтанд хүлээлгэн өгч хэвших;

---oOo---